*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Г.ХАЛИУНБИГЭРИЙН 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Газар зохион байгуулат, геодези, зураг зүйн ерөнхий газар

Нэгжийн нэр: Санхүү эдийн засгийн хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 60.2 | 60.2 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. Санхүү, эдийн засгийн их сургуулийн MBA магистрийн хөтөлбөрийг төгсөх | 15 | 15 |
| 2. | Арга хэмжээ 2. Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын тасралтгүй боловсролын сургалтад хамрагдах | 15 | 15 |
| 3. | Арга хэмжээ 3. Байгууллагаас зохион байгуулах холбогдох зөвлөгөөн, сургалтуудад хамрагдах | 15 | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 15 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 15 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 15 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 15 |
| 4. | Манлайлах | 15 |
| 5. | Багаар ажиллах | 15 |
| 6. | Харилцаа | 15 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | 15 |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | 15 |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | 15 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 15 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | 60.2 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 15 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 90.2 |

***Үнэлгээ өгсөн:*** ЗБГЗЗЕГ-ын дарга

*(албан тушаал)*

***Төсвийн шууд захирагч***

*(гарын үсэг)*

/А. Энхмандах/

*(албан хаагчийн нэр)*

2024.12.20 *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** СЭЗА-ийн дарга

*(албан тушаал)*

***Нэгжийн дарга:***

*(гарын үсэг)*

/Г. Малчинбаяр/

*(албан хаагчийн нэр)*

2024.12.10 *(огноо)*

## ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.3.2 | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулах | Үйл ажиллагаа | Жилийн төлөвлөгөөний төсөл | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан. | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний саналыг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг боловсруулан нийт 9 хөтөлбөр 2 төсөл, 8 арга хэмжээний нийт 138.6 сая төгрөгийн саналыг ЗГХЭГ-т 2024 оны 01 сарын 15-ны өдрийн 1/124 дүгээр албан бичгээр хүргүүлэн ажилласан. Мөн Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 1/1813 дугаар албан бичгийн дагуу тус саналыг ЗГХЭГ-т 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 1/2522 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1. "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах** | | | | | | | |
| 1.24.1.1 | "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд мод тарих | Үйл ажиллагаа | Өмнөх жилд тарьсан модны арчилгааны хувь | 2023 онд тус салбарын хэмжээнд нийт 2876 мод тарьснаас 2643 мод ургаж байна. Тарьсан модыг тогтмол арчлах ажлыг газрууд зохион байгуулан ажиллаж байна. | Салбарын хэмжээнд 750 мод тарьж ургуулах. | 2024 онд агентлаг БЗД-ийн олон улсын цэцэрлэгт хүрээлэнд нийт 450 улиас, бургас, 80 гацуур модыг тарьсан. Тарьсан модны арчилгааг тус цэцэрлэгт хүрээлэн хариуцан ажиллаж байна. Харьяа 22 газруудаас "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжиж бүх нийтээр мод тарих өдрүүдийн хүрээнд нийт 3280 мод тарьсан байна. Нийт салбарын хэмжээнд 3810 мод тарьж, арчлалт хамгаалалт хийж байна. | 100 |
| **ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **4.2.1** | **Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах** | | | | | | |
| 4.2.1.1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний өсвийн төлөвлөлт болон зарцуулалтын эдийн засгийн тооцоо судалгааг хийж холбогдох | Үйл ажиллагаа | Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол, тухайн жилийн төсвийн хязгаар, төсвийн төсөл боловсруулах удирдамжийн дагуу | Монгол улсын 2023 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, зураг | 2025-2027 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг гарган холбогдох тооцоо судалгааг хийсэн байна.<br><br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг Сангийн яамны "Цахим систем"-д холбогдох | 2025-2027 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсвийн төслийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг Сангийн яамны "Цахим систем"-д холбогдох журмын дагуу оруулж, ЗГХЭГ-т цахимаар болон газрын даргын 2024 оны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагуудад хүргүүлж, батлуулах | | боловсруулсан байдал | төсвийн төсөл арга хэмжээний жагсаалтад 2 төсөл арга хэмжээ батлагдаж, хэрэгжүүлсэн. | журмын дагуу оруулж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | 1/1505 дугаар албан бичгээр тус тус хүргүүлээд байна. Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд 1,931.8 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ батлагдсан. | |
| 4.2.1.2 | Агентлаг болон 21 аймгийн ГХБХБГ, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны үндсэн үйл ажиллагааны орлого, урсгал зардлын төсвийн төлөвлөлт тооцоо судалгаа хийж холбогдох байгууллагуудад хүргүүлж, батлуулах | Үйл ажиллагаа | Төсвийн тухай хууль, Тухайн жилийн төсвийн хязгаар, төсвийн төсөл боловсруулах удирдамжийн дагуу боловсруулсан байдал | Монгол улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төв агентлаг, 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА-ны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 3,049.0 сая төгрөг, урсгал зарлагын төсвийг нийт 46,614.4 сая төгрөгөөр батлуулсан. | 2025 оны төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын тооцоо судалгааг хийсэн байна. 2025 оны төсвийн төслийн хязгаарт санал боловсруулан ЗГХЭГ-т болон Сангийн яаманд хүргүүлсэн байна. 2025 оны төсвийн төсөлд 21 аймгийн ГХБХБГ болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас санал авч хянан нэгтгэж, 2025 оны төсвийн төсөл 2026-2027 оны төсвийн төсөөллийг боловсруулан ЗГХЭГ, Сангийн яаманд хүргүүлэн хянуулсан байна. | 2024 оноос 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА-ны үндсэн үйл ажиллагааны бараа үйлчилгээний бусад зардалд батлагдсан зардлыг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр баталсан. Тус зардлаас санхүүжигдэх зардлын нэр төрлийн жагсаалтыг Газрын даргын А/83 дугаар тушаалаар батлуулан харьяа газруудад 2024 оны 1/717 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Киоск машинаас олох орлогыг нэмэгдүүлэх судалгааг хийсэн. 2025 оны төсвийн төслийн хязгаар саналыг боловсруулан ЗГХЭГ-т 1/1330 албан бичгээр хүргүүлсэн болно. Харьяа байгууллагуудын 2025 оны үндсэн үйл ажиллагааны орлогыг 3,295.4 сая төгрөг, урсгал зардлыг 65,336.3 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 108,060.3 сая төгрөг байхаар тооцон саналыг батлагдсан маягт, удирдамжийн дагуу | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлтгэн 2024 оны 1/1817 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэн хянуулж, Сангийн яаманд шаардлагатай зардлуудын талаар тайлбар тодруулгыг өгсөн. 2024 оны улсын төсвийн тодотголд тусгуулах урсгал зардлын 994.2 сая, хөрөнгийн зардлын 18,992.9 сая төгрөгийн саналыг боловсруулан, ЗГХЭГ-т 2024 оны 1/1811 дүгээр албан бичгээр хүргүүлж, урсгал зардлыг батлуулсан. | |
| 4.2.1.3 | Газрын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгах төсөл, арга хэмжээний төсвийг батлуулах | Үйл ажилла гаа | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөсөн байдал | 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 12 төрлийн бараа ажил үйлчилгээг төлөвлөн, 100 хувь хэрэгжүүлсэн. | 2024 оны төсвийн урсгал зардлаар хийгдэх бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөнд санал авч, нэгтгэн боловсруулсан байна.<br>2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулсан байна. | 2024 оны төсвийн урсал зардлаар хэрэгжүүлэх бараа, ажил үйлчилгээний саналыг газар, хэлтсүүдээс санал авч нэгтгэн хянаж, 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгах бараа ажил үйлчилгээний, урсгал үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх төсвийн төлөвлөлтийг хийж зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай байгаа бараа ажил үйлчилгээний зардлыг төсвийн зохицуулалтын саналыг бэлтгэн Сангийн яаманд хүргүүлэн батлуууллаа. Нэгжүүдээс 2024 онд хэрэгжүүлэх гэрээт ажлуудын саналыг батлагдсан төсөвтэй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | уялдуулан хянаж нэгтгэн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Газрын даргын А/10 дугаар тушаалаар батлуулсан. 2024 онд нийт 1,363.0 сая төгрөгийн 17 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг худалдан авч хэрэгжүүлэхээр тусгалаа. Газрын даргын 2024 оны А/263 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт орж, 170.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ажил хасагдаж, 662.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ажил нэмэгдэж, 1 ажлын төсөвт өртөгт өөрчлөлт орсон. | |
| 4.2.1.4 | Агентлаг болон 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн ГЗБА-ны үндсэн үйл ажиллагааны орлого, урсгал зардлын сар, улирлын төсвийн хуваарийн саналыг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлж, төсвийн Fiscal | Үйл ажилла гаа | Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын дагуу боловсруулсан байдал | Монгол улсын 2023 урсгал зардлын төсвийн сар улирлын хуваарийн саналыг боловсруулан БХБ-ын сайд (ТЕЗ)-д хүргүүлэн, Сангийн сайдаар батлуулан ажилласан. | Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг боловсруулан, төсвийн фискал програмд оруулж, ЗГХЭГ болон Сангийн яаманд хүргүүлж батлуулсан байна.<br>Агентлаг, 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн ГЗБА-нд батлагдсан төсвийн хуваарийг хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд төсөвт зохицуулалт хийж, байгууллагуудын үйл | 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА, төв агентлаг 2024 онд нийт 46,614.4 сая төгрөгийн урсгал зардлын төсөв батлуулан ажиллаж байна. Үүнээс 43,565.4 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс 3,049.0 сая төгрөгийг төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлнэ. 2024 оны төсвийн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны саналыг харьяа байгууллагуудаас авч хянан зардлын санхүүжилтийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | програмд оруулж, батлуулах | | | | ажиллагааг доголдолгүй ажиллуулах санал боловсруулж, хэрэгжүүлж ажилласан байна. | хуваарьт өөрчлөлт оруулах саналыг бэлтгэн Сангийн яаманд хүргүүлэн санхүүжилтийн хуваарь зохицуулалтыг батлуулан ажиллаж байна. 2024 онд нийт 10 удаа төсвийн хуваарийн болон зохицуулалтуудын саналыг 2024 оны 1/308, 1/455, 1/723, 1/773, 1/1107, 1/1383, 1/1636/, 1/1773, 1/2717, 1/3351 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлэн батлуулж ажиллалаа. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан, нийт 23 байгууллагын цалин хөлсний хүлээгдэж буй гүйцэтгэлийн судалгааг гаргаж, тодотгосон төсвийн хуваарийн саналыг ЗГХЭГ-т 2024 оны 1/2328 дугаар албан бичгээр хүргүүлж, батлуулсан. Харьяа 22 байгууллагад 2024 оны 1/2440-1/2456 дугаар албан бичгээр төсвийн хуваарийг хүргүүлэв. | |
| 4.2.1.5 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | Үйл ажиллагаа | Засгийн газрын 2014 оны 384 дугаар тогтоолын дагуу Шилэн дансны цахим хуудсанд | Засгийн газрын 2014 оны 384 дугаар тогтоолын дагуу Шилэн дансны цахим | Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааны тайлбар сар, улирал, бүтэн жилээр мэдээлсэн байна. | 2024 оны 4 дүгээр улиралд нийт 192 мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлэж ажиллалаа. | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээлсэн байдал | хуудсанд байгууллагын 2023 оны холбогдох мэдээ, тайланг хуулийн хугацаанд мэдээлсэн. | Тухайн жилийн төсөвт нэмэлт өөрчлөлт орсон тухай мэдээллийг оруулсан байна.<br>2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг шилэн дансанд мэдээлсэн байна.<br>2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг шилэн дансанд мэдээлсэн байна.<br>2023 оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан жилийн тайланг шилэн дансанд мэдээлсэн байна.<br>Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээг шилэн дансанд мэдээлсэн байна.<br>Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хамт шилэн дансанд мэдээлсэн байна.<br>Хандив тусламжийн хэмжээ түүний зарцуулалтын жилийн тайланг шилэн дансанд мэдээлсэн байна. | | |
| 4.2.1.6 | Агентлаг, 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн | | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд | - | Агентлаг, 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн ГЗБА-ны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг | 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА-ны 2024 оны 4-р улирлын байдлаар харьяа байгууллагуудын 1-11 сарын | 95 |

90

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ГЗБА-ны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих | Үйл ажиллагаа | хяналт тавьсан байдал | | хангаж, Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг хуулийн хугацаанд оруулсан эсэхэд хяналт тавьж ажилласан байна. | хугацаанд оруулсан шилэн дансны мэдээлэлд хяналт хийж дүн мэдээллийг нэгтгэн удирдлагууд танилцуулсан. Хугацаа хоцроож мэдээллэсэн болон шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандартын тухай журамд зааснаас бусад мэдээллийг оруулсан газруудад зөвлөмж хүргүүлэн ажиллалаа. | |
| **4.2.2** | **Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх** | | | | | | |
| 4.2.2.1 | Газрын санхүүгийн тайлан, нэгдсэн санхүүгийн тайланг олон улсын стандарт, холбогдох хууль тогтоомжийн дагуу тайлагнаж, холбогдох дээд шатны байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайланг бэлтгэж, хүргүүлсэн байдал | Газрын 2022 оны жилийн эцэс, 2023 оны хагас жилийн санхүүгийн тайлан болон нэгтгэл санхүүгийн тайланг УСНББОУС, хууль тогтоомжийн дагуу тайлагнан, БХБЯ, Сангийн яаманд хүргүүлсэн. | Газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн ГЗБА-ны санхүүгийн тайланг нэгтгэж, агентлагийн нэгтгэсэн тайланг “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, хууль тогтоомжийн дагуу тайлагнан холбогдох газруудад хүргүүлсэн байна. Агентлагийн 2024 оны улирал, жилийн эцсийн санхүүгийн тайлан, 21 аймаг, нийслэлийн ГЗБА-ны санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн, нэгтгэсэн санхүүгийн тайланг холбогдох дээд шатны | Агентлагын 2023 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд тайлагнаж, аймгуудын ГХБХБГ болон НГЗБА-ны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэх ажлыг 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд зохион байгуулж, ГЗБГЗЗГазрын нэгтгэсэн тайланг гаргалаа. 2024 оны 2 дугаар сарын 25-наас 3 дугаар сарын 31 хүртэл байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайланг гарган, Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Харьяа газруудын 2023 оны тайлан гаргахтай холбоотойгоор санхүүгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагад хүргүүлсэн байна. | программыг баазаар татан авч хяналт хийн санхүүгийн тайлантай тулган шалгалаа.<br>Харьяа газруудын нягтлан бодогч нарын сургалтыг 2 дугаар сарын 18-наас 23-ны өдрийн хооронд зохион байгуулж, тайланг нэгтгэн ажилалаа.<br>Мөн харьяа газруудын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтүүдийг авч тавигдсан зөвлөмж, акт, албан шаардлагыг нэгтгэн газрын даргад танилцууллаа.<br>Харьяа газруудад даргын 2024 оны 1/1219 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн. Харьяа газруудын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг шалган хүлээн авч нэгтгэх ажлыг 2024 оны 7 дугаар сарын 5-25-ны өдрүүдэд хийж гүйцтэгэлээ.<br>2024 оны энхий хагас жилийн санхүүгийн нэгдсэн тайланг 2024 оны 7 дугаар сарын 25-нд гарган холбогдох газруудад хүргүүлсэн.<br>2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг гарган, харьяа газруудын тайланг шалган хүлээн авлаа. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.2.2 | Газрын 2023 оны санхүүгийн тайлан, нэгтгэсэн санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт хүргүүлж, аудитын тайлан, дүгнэлт гаргуулах | Үйл ажиллагаа | Төрийн аудитын тухай хуулийн 15.1, 18.2 дахь заалтын дагуу санхүүгийн тайланг хүргүүлж, аудитын тайлан дүгнэлт гаргуулсан байдал | Газрын 2022 оны санхүүгийн тайлан, нэгтгсэн санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт хүргүүлж, Үндэсний аудитын газраас тус газрын санхүүгийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй дүгнэлт" өгсөн. | Газрын 2023 оны санхүүгийн тайлан болон агентлаг, 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн ГЗБА-ны 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, холбогдох тайлан, баримтыг тус тус Үндэсний аудитын газарт хуулийн хугацаанд хүргүүлж, аудитын дүгнэлтийг гаргуулсан байна. | 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг гарган 2024 оны 03 дугаар сарын 24-ны 1/562 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж, үйл ажиллагаа болон төсвийн гүйцэтгэл, төсвийн төлөвлөлтөнд хийгдсэн аудитын шалгалтанд холбогдох материал тооцоо судалгааг нэгтгэн гарган өгч ажиллаж байна.<br>2023 оны нэгтгэсэн тайлан "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт авч 19 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалты газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын газар "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт, Булган, Увс аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар "Хязгаарлалттай" санал дүгнэлт тус тус авсан байна.<br>2023 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, түүний биелэлтийг гарган Үндэсний аудитын газарт хүргүүлж холбогдох мэдээг аудитын программад оруулж тайлагналаа. | 100 |
| **4.2.3** | **Хөрөнгө өр төлбөр төсвийн санхүүжилтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.3.1 | Байгууллагын хөрөнгийн бүртгэлийг үнэн зөв хөтлөх, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, хагас бүтэн жилийн тооллогыг хуулийн хугацаанд хийх | Үйл ажиллагаа | 2022 оны хөрөнгийн бүртгэлийг олон улсын стандартын дагуу бүртгэн, тооллогыг хийж, хөрөнгийн бүртгэлд хяналт тавьж ажилласан. | 2023 оны хөрөнгийн бүртгэлийг олон улсын стандартын дагуу бүртгэн, тооллогыг хийж, хөрөнгийн бүртгэлд хяналт тавьж ажилласан. | Хөрөнгийн бүртгэлийг хууль, олон улсын стандартын дагуу бүртгэж, холбогдох тайлангуудыг үнэн зөв гаргасан байна. Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр чанартай зохион байгуулж, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг тухай бүр холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | ТӨБЗГ-ын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай" 29 дүгээр тогтоолын дагуу 203 нэрийн 931.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн, "Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх тухай" 32 дугаар тогтоолын дагуу 9 нэрийн 13.0 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж холбогдох аймгийн ГХБХБГазрын балансад шилжүүлсэн. 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А-1/135 дугаар "Зөвшөөрөл олгох тухай" албан бичгийн дагуу 14.7 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад харьяа аймгийн ГХБХБГазарт шилжүүлэн ажилласан. ТӨБЗГ-ын 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн "Зөвшөөрөл олгох тухай" А-1/1629 дүгээр албан бичгийн дагуу дагуу 18 нэрийн 100.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг харьяа байгууллагад шилжүүлсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар 2609 ширхэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үндсэн хөрөнгийн элэгдэлийн зардлыг Fiscus.stg.mn болон acolous 2024 санхүүгийн программд бүртгэн ажиллалаа. | |
| 4.2.3.2 | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт холбогдох тайлан мэдээг хүргүүлж, дүгнүүлэх | Үйл ажиллагаа | 1 тайлан | 2022 оны Төрийн өмчийн эд хөрөнгийн өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг гарган ТӨБЗГ-т хүргүүлж "А" үнэлэгдсэн. | 2023 оны Төрийн өмчийн эд хөрөнгийн өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийн тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлж, дүгнүүлсэн байна. | 21 аймгийн ГХБХБГазар болон НГЗБА ирүүлсэн захиалгын хуудсын дагуу нийт 5 ширхэг УТХГАшиглах гэрчилгээг бүртгэсэн. Худалдан авагч: Баянхонгор аймаг ГХБХБГазар, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн даргаар төлөвлөгөө батлуулан 4 удаа хуралдаж хөрөнгө актлах, устгах, шинээр худалдан авах зэрэг шийдвэрийг гаргууллаа. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт холбогдох хөрөнгө материалтай холбоотой биелэлтийг тухай бүр нь гаргаж өгч ажилласан. Байгууллагын нэр өөрчлөгдсөнтэй холбоотой шинээр тамга тэмдэг хийгдсэн тул нийт 118 ширхэг 9.2 сая төгрөгийн үнэ бүхий хуучин эвдэрч хэмхэрсэн дахин ашиглах боломжгүй болсон тамга тэмдэг, дардас, өмсгөл, бусад бараа материалын танилцуулга жагсаалтыг бэлтгэн Удирдлага болон Өмч | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамгаалах байнгын зөвлөлөөр оруулан танилцуулж баталгаажуулан ажилласан.<br>2024 оны 4-р улирлын байдлаар гэрчилгээний нийт 2840 ширхэг 9.6 сая төгрөгийн үнэ бүхий орлого орж, 51895 ширхэг 39.3 сая төгрөгийн зарлагын гүйлгээг бүртгэж, холбогдох журнал бичилт, тайланг анхан шатны баримтыг хянаж үндэслэн хийж ажилласан | |
| 4.2.3.3 | Албан хаагчдын цалин хөлс, холбогдох тооцооллыг сар бүр тогтоосон хугацаанд тооцон олгож, нийгмийн даатгал, татварын тайланг гаргаж, хуулийн хугацаанд тайлагнах, төлөлтөд хяналт тавих | Үйл ажиллагаа | Авлага, өр төлбөр үүсгэхгүй ажилласан байдал | 2023 онд албан хаагчдын цалин хөлсийг тооцон олгож, ХХОАТ, НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд холбогдох байгууллагуудад тайлагнасан. Авлага, өр төлбөр үүсгэхгүй ажилласан. | Албан хаагчдын цалин хөлс, листийг сар бүр хугацаанд нь тооцон олгосон байна.<br>ХХОАТ-ын тайланг улирал бүрийн дараа сарын 20-ны дотор, НДШ-ийн тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор тайлагнаж, өр авлага үүсгэхгүй ажилласан байна. | 4-р улирлалын байдлаар нийт 86 албан хаагчид цагийн бүртгэл, бусад холбогдох тушаал шийдвэр, хууль тогтоомжийг үндэслэн 2,824,5 сая төгрөгийн цалин бодож олгоод байна.<br>Нийгмийн даатгалын шимтгэл ажил олгогчоос 323.6 сая төгрөг, даатгуулагчаас 295.7 сая төгрөг, хувь хүний орлогын албан татвар 217.5 сая төгрөг тус тус тооцож олгосон.<br>Нийт 19 албан хаагчийн хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн тооцоог хийж, 6.4 сая төгрөгийг хууль журмын дагуу бодож олгосон.<br>Тухай бүрт гарсан тушаал шийдвэрийг үндэслэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шаардлагатай нэмэгдэл, урамшуулал тэтгэмжийг цалин дээр бодож олгож байна.<br><br>Ажил гүйцэтгэх гэрээгээр 4-р улирлын байдлаар нийт 12 албан хаагч гэрээ байгуулан ажиллаж байгаа, гэрээний дагуу цалинг хугацаанд нь бодож, нийт 66.6 сая төгрөг олгосон.<br><br>Нийгмийн даатгалын шимтгэл даатгуулагчаас 7.1 сая төгрөг, ажил олгогчоос 7.2 сая төгрөг, хувь хүний орлогын албан татвар 5.5 сая төгрөг тооцсон.<br><br>Архивын ерөнхий газрын даргын 2024 оны 1 сарын 2-ны өдрийн А/01 тоот “Цахимжуулалт хариуцсан ажилтнуудын орон тоог хуваарилах, гэрээ байгуулах эрхийг шилжүүлэх” тушаалын дагуу ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан 4 гэрээт ажилтнуудын 40.9 сая төгрөгийн цалинг сар бүр тооцож, холбогдох нийгмийн даатгал, татварын тооцоог хуулийн хугацаанд тайлагнан ажилласан.<br><br>4-р улирлын байдлаар үндсэн ажилтан 86, хүүхдээ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | асарч байгаа 6, сурч байгаа 1, гэрээт ажилтан 9 нийт 102 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг программд хүн тус бүрээр шивж оруулан, өр үүсгэлгүй тайлант хугацаанд баталгаажуулан ажиллаж байна.<br><br>Нийгмийн даатгалын тайланд нийгмийн даатгалын шимтгэл /ажил олгогч, даатгуулагч/ төлөлт нийт 637.9 сая төгрөг байна. Үндсэн албан хаагч 619.3 сая төгрөг, гэрээт албан хаагч 14.4 сая төгрөгийг тус тус тайлагнасан. | |
| 4.2.3.4 | Газрын 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан гэрээт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжүүлэх | Үйл ажиллагаа | Гэрээт ажлын гүйцэтгэл | Газрын 2023 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан гэрээт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжүүлтийг олгож ажиллалаа. Байгууллагын болон хувь хүнтэй холбоотой өр авлага үүсээгүй байна. | Газрын 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан гэрээт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжилтийг олгон, өр авлага үүсгэхгүй ажилласан байна.<br><br>Байгууллагын болон хувь хүнтэй холбоотой өр авлагын бүртгэлийг тухай бүрд нь бүртгэж тайлагнасан байна.<br><br>Хуримтлагдсан өглөг авлагыг барагдуулж ажилласан байна | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2024 оны ХАА-ны төлөвлөгөөнд 18 төсөл, арга хэмжээний нийт 1,777.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан. Үүнээс 12 төсөл, арга хэмжээний нийт 939.9 сая төгрөгийн гэрээт ажил 100 хувь хэрэгжиж, санхүүжилтийг бүрэн олгосон. Үүнээс 3 төсөл, арга хэмжээний нийт 219.5 сая төгрөгийн гэрээт ажлын дундын шатны тайланд 110.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 3 төсөл, арга хэмжээний нийт 460.7 сая | 95 |

98

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийн гэрээт ажлын гүйцэтгэл ирээгүй тул санхүүжилт олгогдоогүй байна.<br>Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй, "Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор" ТӨААТҮГ-тай 2004 оны 07 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан дугаар-49 "Хамтран ажиллах гэрээ"-ний үлдэгдлээс үүссэн 2.2 сая төгрөгийн авлагыг газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэн найдваргүй авлагад бүртгэсэн.<br>Мөн 2004 онд үүссэн иргэн Ууганжаргалын авлагыг бууруулах талаар Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны шийдвэр гүйцэтгэгч Оюунцэцэгтэй 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр утсаар /89086122/ холбогдож төлбөрийг барагдуулах талаар хүсэлтийг дахин тавьсан. Мөн даргын 2024 оны 1/1130 дугаар албан бичгээр Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгүүлэх албанд дэмжлэг үзүүлэх талаар хүсэлт өгсөн. 2023 онд үүссэн аймгийн ГХБХБГазруудын Барилгын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжлийн төвөөс авах 1,714,254.6 төгрөгийн авлагыг эхний хагас жилд багтаан бүрэн барагдуулж өмнөх оны авлагыг буурууллаа. | |
| 4.2.3.5 | Батлагдсан төсвийн дагуу төсвийн санхүүжилтийг холбогдох журмын дагуу хийж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гарган ЗГХЭГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | Төсвийн гүйцэтгэлийн мэдээ | 2023 оны төсвийн санхүүжилтийг 96.1 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. | Төсвийг зориулалтын дагуу санхүүжилтийн зарцуулалтыг тухай бүр холбогдох журмын дагуу хийж, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг гарган ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Үндсэн үйл ажиллагааны данс болон нэмэлт санхүүжилтийн данснаас санхүүжүүлэх 3,581.2 сая төгрөгийн зардлын эрх нээлгэх хүсэлтийг Сангийн яаманд тухай бүр хүргүүлэн санхүүжилтийг шийдвэрлүүлэн ажилласан.<br>Газрын 100900008063, 100900008436,100900008374 тоот харилцах дансны гүйлгээг өдөр бүр дансны хуулгатай тулган шалгаж, ажиллаж байна.<br>Харилцах дансны харилцахын тайланг сар бүр гарган, тайлагнасан.<br>Мөн худалдан авсан бараа материалын и-баримтыг тулгалт хийж, баримтыг шивүүлэн ажиллаж байна. Орон нутгийн 1-11 дүгээр сарын мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд гаргуулан авч хянаж нэгтгэн байгууллагын удирдлага болон ЗГХЭГазарт хүргүүлж, харьяа газруудыг нягтлан бодох бүртгэл, санхүү, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төсвийн удирдлагаар хангаж ажиллалаа.<br>Сар бүрийн орлогын залруулга хийлгэх хүсэлтийг илгээн залруулгыг хийж орлогыг гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. | |
| 4.2.3.6 | Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах хангамж, хөрөнгө, засварын үйл ажиллагааг зохион байгуулж, аж ахуйн үйл ажиллагаар хангаж ажиллах | Үйл ажилла гаа | Батлагдсан төсвийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын тоо | Байгууллагын аж ахуйн үйл ажиллагааг жигд хангаж ажиллаж, албан томилолт, шүүхийн шинжээчийн дүгнэлт гаргах ажлын хэсэг болон байгууллагын үйл ажиллагаанд автомашинаар үйлчилсэн. | Байгууллагын аж ахуйн үйл ажиллагааг жигд хангаж ажилласан байна.<br>Албан томилолт, шүүхийн шинжээчийн дүгнэлт гаргах ажлын хэсэг болон байгууллагын үйл ажиллагаанд автомашинаар үйлчилсэн байна.<br>Автомашины бүрэн бүтэн байдлыг хангаж ажилласан байна. | Албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулж GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын өрөөнд 3.7 сая төгрөгийн 2 шүүгээ, Геодезийн лабораторын өрөөг 14.6 сая төгрөгөөр иж бүрэн засварлаж, багажны тавиурыг шинэчлэсэн.<br>Мөн байрны 116, 117, 122, 202А, 202В тоот өрөөнүүдэд 13.0 сая төгрөгөөр урсгал засвар хийсэн.<br>2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 165 ширхэг 249.0 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 64 ширхэг 54.6 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан. Мөн хандив тусламжаар 13 ширхэг 150.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч, албан хаагчдын ажлын хэрэгцээнд олгож ажиллалаа.<br>Ланд-200 маркийн 5018УАК, соната маркийн 07-75УБҮ , гэрээгээр ашиглаж байгаа | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Альфард маркийн 94-09УНЭ автомашинуудын даатгалын гэрээг хийж, автомашинуудын оношилгоог хийж шаардлагатай засвар үйлчилгээнд 19.2 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч урсгал засварыг тухай бүр хийж машины бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллаж байна.<br>Малчинтай байгуулсан гэрээний дагуу 2024 1-р улиралд цаг агаарын байдал хүндэрсэнтэй холбогдуулан малын хорогдол гарсан тул 2024 оны 02 сарын 26-27-ны өдрүүдэд төв аймагт ажиллаж малын өвөлжөө, хаваржаа, өвс тэжээл, хорогдсон малын нөхцөл байдалтай танилцаж, баримтаар баталгаажуулан Удирдлага, Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулсан.<br>Гэрээнд заасны дагуу өвөлжилт хүндэрсэн тохиолдолд малчинд өвс тэжээлээр дэмжлэг үзүүлнэ гэсний дагуу 2.0 сая төгрөгийн өвс тэжээлээр хангаж ажилласан.<br>Байгууллагын авто машины жилийн татвар, оношлогоо даатгалыг хувиарын дагуу | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | татварын төлөлтийг хийлгэж, Үйл ажиллагаатай холбоотой гэрээт байгууллагуудтай улирлын гэрээг байгуулан ахлах нягтлан болон хэлтсийн даргад хянуулан ажилласан. Байгууллагын 3 авто машиныг хуваарийн дагуу Улсын үзлэг, оношилгоонд хамруулахаар ажиллаж байна. | |
| 4.2.3.7 | Агентлаг болон харьяа байгууллагуудын “Acolous” санхүүгийн програмыг онлайн суурьт програмд шилжүүлэх | Үйл ажиллагаа | Онлайн суурьт програмд шилжсэн байгууллагын тоо | Төв агентлаг болон харьяа байгууллагуудын “Acolous” санхүүгийн програмыг ашиглаж байна. | Агентлаг болон харьяа байгууллагуудын “Acolous” санхүүгийн програмыг онлайн суурьт програмд шилжүүлж, Төрийн сангийн удирдлагын цахим системтэй холбох, бүртгэл хөтлөлтийг сайжруулж ажилласан байна. | Агентлаг болон харьяа байгууллагуудын “Acolous” санхүүгийн програмыг онлайн суурьт програмд шилжүүлэх ажлыг 2024 оны 2 дугаар сарын 21-22-ны хооронд зохион байгуулан, программын хэрэглээний талаар сургалт хийж, 2024 оны эхний үлдэгдлийг хөрвүүлэх ажлыг Санхүүгийн тооцоолох групптай хамтран хийж гүйцэтгэлээ. 4-р улирлын урьдчилсан байдлаар 21 аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, НГЗБА, агентлаг онлайн суурьт программыг бүрэн нэвтрүүлээд байна. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг онлайн суурьт программаар гарган нэгтгэхээр харьяа газруудад | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шаардлагыг өгөн хяналт тавин, программын талаар шаардлагатай зөвлөмж, сургалтыг өгч ажиллаж байна. | |
| **ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| 4.1.1 | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | Үйл ажиллагаа | Үүрэг даалгаврын тоо | Жил бүр хийгддэг. | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна. | 4-р улирлын байдлаар нийт 51 үүрэг даалгавар удирдах ажилтны шуурхайгаас зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаварыг цаг тухайд нь хэрэгжүүлж тайлагнан ажилласан. | 100 |
| 4.1.2 | Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Тушаалд заасан хугацаа | Хэнтий, Дорнод, Өмнөговь, Дундговь аймгуудад хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн. | Батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилд оролцсон байна. | Газрын даргын тушаалаар байгуулагдсан холбогдох ажлын хэсгүүдэд 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан нийт 4 үнэлгээний хороонд ахлах мэргэжилтэн гишүүнээр ажилласан. | 100 |
| 4.1.3 | Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | ЗГ-ын 2023 оны 55 дугаар тогтоол, ЗГ-ын хуралдааны 2023 оны 08 дугаар тэмдэглэл, ЗГ-ын 2023 оны 213 дугаар тогтоол, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоол, | Холбогдогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна. | Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаарыг бараа ажил үйлчилгээг худалдан авахад баримтлан ажиллаж байна. Тогтоол шийдвэрийг биелэлтийг цаг хугацаанд гарган тайлагнан ажиллаж байна. | 100 |

104

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | БХБС-ын 2023 оны 28 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажилласан. | | | |
| 4.1.4 | Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | Үйл ажилла гаа | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо | 2023 онд 241 бичиг үүнээс хариутай 49 хариугүй 192 бичиг ирсэн байна. Хугацаатай бичгийг заасан хугацаанд нь шийдвэрлэсэн. | Нэгжид ирсэн албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Нийт 257 албан бичиг ирж, хариуг цаг хугацаанд нь хариуг нь өгч ажилласан. Нийт 230 албан бичиг хамтран ажиллагч, харьяа байгууллагуудад хүргүүлсэн. | 100 |
| 4.1.5 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Үйл ажилла гаа | Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо | 2023 онд нийт 35 нэгж архивын баримт материалыг хүлээлгэн өгсөн. | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгсөн байна. | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 оны санхүүгийн нийт 36 ажлын баримт бичгийг архивын нэгж болгосон. Байгууллагын архивын эрхлэгчид хүлээлгэн өгсөн. | 100 |

## ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5.1 | Санхүү, эдийн засгийн их сургуулийн MBA магистрийн хөтөлбөрийг төгсөх | Магистрийн зэрэг хамгаалах | | Санхүү, эдийн засгийн их сургуулийн Санхүү менежментийн MBA магистрийн хөтөлбөрийг төгсөнө. | Санхүү, эдийн засгийн их сургуулийн MBA магистрийн хөтөлбөрийг E20241679 дипломтой төгссөн. | 100 |
| 5.2 | Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын тасралтгүй боловсролын сургалтад хамрагдах | Мэргэжлийн сургалтад хамрагдах | | ММНБИ-ээс 2024 онд зохион байгуулах сургалтуудад хамрагдаж, мэргэжлийн чиглэлээр шинэ мэдлэг, мэдээллийг эзэмшинэ. | 2024 оны 10 сар сургалтанд хамрагдсан. | 100 |
| 5.3 | Байгууллагаас зохион байгуулах холбогдох зөвлөгөөн, сургалтуудад хамрагдах | Байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдах | | Байгууллагаас зохион байгуулах холбогдох зөвлөгөөн, сургалтуудад хамрагдана. | Байгууллагаас зохион байгуулсан сургалтад тогтмол хамрагдлаа. | 100 |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* ***Төсвийн шууд захирагч***

Газрын дарга ........................ (А.Энхманлай)

*(огноо)* ........................

*Тайлагнасан:* ***Нэгжийн дарга***

Санхүү, эдийн эдийн засгийн хэлтэс ........................ (Г.Халиунбигэр)

*(огноо)* 2024.12.04